



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 4/409

Улиастай

Аймгийг бүрэн камержуулах, гэрэлтүүлэг хийх нэгдсэн төлөвлөлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1.7 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.1.15 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор бүх сумын орох, гарах зам, Улиастайн гудамжууд, бүх нийтийн эзэмшлийн зам, талбай, сургууль, цэцэрлэгийн орчинд шинээр суурилуулах камер, гэрэлтүүлгийн зураглал, төлөвлөлтийг гаргах, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч Г.Мягмарсүрэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Д.Азжаргал

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

У.Батдаваа

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Д.Анхтэс

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Н.Отгонжаргал

Завхан аймаг дахь Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа

Д.Бямбацогт

Аймгийн Боловсрол, Шинжлэх ухааны газрын дарга

Х.Онолбаатар

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

Д.Дамдинбазар

"Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн Завхан аймгийн газрын дарга

С.Шаарийбуу

"Цахилгаан холбоо" ХХК-ийн Завхан салбарын захирал

Захирамж-2023

8109010966

Г.Бадамхатан

"Алтай-Улиастай Эрчим хүчний систем" ТӨХК-ийн Завхан салбарын захирал

П.Ганзориг
Ц.Оросоо

Аймгийн Автотээврийн төвийн дарга
Аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга

Х.Дэлгэрдалай
Ж.Лхагвасүрэн

Аймгийн ерөнхий Архитектор
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Г.Амарсайхан

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга

Сумын Засаг дарга, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нар

Нарийн бичгийн
дарга:

Ц.Алтангэрэл

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Э.Лувсанданзан

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

2.Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, төлөвлөлт зураглалыг хийлгэж, 2023 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Засаг даргад тайлагнахыг ажлын хэсэг (Г.Мягмарсүрэн)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Н.Бямбадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ӨНӨРБЯАР